

**ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН АВЛИГЫН ЭРСДЭЛЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЙЛ  
АЖИЛЛАГААНЫ 2018 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

2018 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр

Улаанбаатар хот

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Үйл ажиллагааг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээ	Үнэлгээ	
<b>НЭГ. ХУУЛИАР ХҮЛЭЭСЭН ҮҮРГИЙН БИЕЛЭЛТ</b>				Оноо	Хувь
1	Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, энэ талаарх мэдээллийг иргэд, байгууллага чөлөөтэй авах нөхцөлийг хангах.	1.1. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор авлигын талаар мэдээлэх утас, авлигаас ангид байх санамж, сэрэмжлүүлэг, авлигын хор хөнөөлийн талаарх зурагт хуудас, шторк хийлгэх, Авлигатай тэмцэх газраас бэлтгэн хүргүүлсэн сурталчилгааны материалыг иргэд, байгууллага, алба хаагчдад түгээж сурталчилах.	Нийслэлийн цагдаагийн газрын алба хаагчдыг авлигаас ангид байх, урьдчилан сэргийлэх, шударгаар ажиллах зарчмыг хэрэгжүүлж, хэвшүүлэх, Авлигатай тэмцэх тухай хуулийг сурталчилах зорлигоор Авлигатай тэмцэх газраас бэлтгэн ирүүлсэн сурталчилгааны 6 ширхэг зурагт хуудсыг тус газрын Санхүү аж ахуйн хэлтсээс хөрөнгийг гаргуулан, 50х30 хэмжээтэй жаазлан, байрны үүдний хэсэгт болон хоёр, гурав, дөрвөн давхруудад байрлуулж, харьяа дүүрэг дэх цагдаагийн хэлтсүүдэд зурагт хуудсыг 2018 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн 30е/2428 дугаартай албан бичгээр хүргүүлж, хэлтсийн байрнуудад жаазлан байрлуулсан. Тус газрын эрх бүхий албан тушаалтан нарыг харьяа газар, хэлтэс, дүүрэг дэх цагдаагийн хэлтэст 1-2 хоногийн хугацаатай томилон ажиллуулж, “Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг бөглөх аргачлал”, Авлигатай тэмцэх газрын мэдүүлгийн бүрдүүлэлтийн програмд нэвтэрч мэдүүлэг бөглөх” талаар арга зүйн сургалтыг зохион байгуулж, Хүний нөөц, сургалтын хэлтсээс боловсруулсан Хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийг бөглөх 80 ширхэг зөвлөмжийг харьяа дүүрэг дэх цагдаагийн хэлтсүүдэд хүргүүлсэн. Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн сурталчилгааны 1 төрлийн 10 ширхэг зурагт хуудас, “Авлигын эсрэг хууль тогтоомжийг таниулах нь” гэсэн гарын авлага 18 ширхэг, Хүний нөөц, сургалтын хэлтсээс боловсруулсан шинээр томилогдсон болон их хэмжээний өөрчлөлт орсон үед Хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлэг мэдүүлэх хугацааны талаарх 1 төрлийн 30 ширхэг санамжийг харьяа дүүрэг дэх цагдаагийн хэлтсүүдэд хүргүүлсэн.	100	5
		1.2. Авлигын аливаа хэлбэрийг үл тэвчих алба хаагчдын сэтгэл зүйг төлөвшүүлэх, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн	Нийслэлийн цагдаагийн газрын даргын 2018 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн баталсан удирдамжийн дагуу цагдаагийн байгууллагын үндсэн үйл ажиллагаа, байгууллагад оршиж буй алдаа доголдол, алба хаагчийн сахилга ёс зүйг сайжруулах, ажлын үр бүтээмжийг нэмэгдүүлэхэд алба хаагчийн гэр бүлийн	100	5

		<p>мэдээлэл сурталчилгаа явуулах</p>	<p>гишүүдийн санал сэтгэгдлийг судалж, цаашид юунд анхаарах арга замыг тодорхойлох зорилгоор Сонгинохайрхан, Баянзүрх дүүрэг дэх цагдаагийн нэгдүгээр хэлтсүүдийн нийт 304 алба хаагчийн 231 гэр бүлийн гишүүдээс санал асуулга авч дүгнэж, газрын даргад танилцуулсан.</p> <p>Тус цагдаагийн газрын Хүний нөөц сургалтын хэлтсийн хамт олноос гаргасан <b>“Эелдэг харьцааг эрхэмлэн шуурхай ажиллагааг хэвшүүлж, үйлчлүүлэгчийн эрх ашгийг дээдлэе”</b> уриалгын хүрээнд байгууллагын үйл ажиллагаа, алба хаагчдын ажлын хариуцлага, ёс зүй, шударга, шуурхай байдлын талаар Нийслэлийн 7 дүүрэг дэх цагдаагийн нэг, хоёр, гуравдугаар хэлтсээр үйлчлүүлсэн нийт 399 иргэнээс санал асуулга авч, дүнг нэгтгэж, дүүрэг дэх цагдаагийн хэлтэс тус бүрээр дүнг гаргаж, иргэдийн санал, хүсэлт, гомдлын мөрөөр тодорхой ажил зохион байгуулан, 2018 оны 05 дугаар сарын 25-ны өдөр дүнг ирүүлэх тухай албан бичгийг энэ оны 04 дүгээр сарын 18-ны өдөр дүүрэг дэх цагдаагийн хэлтсийн дарга нарын нэр дээр хүргүүлж, зохион байгуулж буй ажлын явц, үр дүнгийн талаарх танилцуулгыг дэд бөгөөд Захиргааны удирдлагын газраар уламжлан газрын даргад танилцуулж, ажлын чиглэл авч, хэрэгжилтийг ханган ажилласны үр дүнд алба хаагчдаас иргэнтэй догшин ширүүн, ууртай харьцдаг харилцаа, хандлагаа өөрчлөх, иргэдийг угтан авах, холбогдох алба хаагчидтай шуурхай уулзуулах, иргэнтэй уулзах үед нь эелдэг боловсон харьцах талаар шинэлэг санал, санаалчилга гаргаж байгаа зэрэг эерэг хандлага, ажил, арга хэмжээний эхлэл тавигдаж байна.</p> <p>Цагдаа-Дотоодын цэргийн байгууллагын 2018 оны дэвшүүлсэн зорилт, удирдлага зохион байгуулалт, удирдлагын арга барил, цаашид байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад анхаарах асуудал, алба хаагчдын сахилга ёс зүйн төлөв байдал, ажлын ачаалал, алба хаагчдын нийгмийн асуудлын талаарх сэтгэл ханамжийн санал асуулгыг нийт 92 байгууллагын 12572 алба хаагчаас, тухайн байгууллагын үйл ажиллагаа, хүнд суртал, харилцааны соёлын түвшинг үнэлүүлэхээр 1753 иргэнээс тус тус авч, түүвэрлэн нэгтгэж, санал, дүгнэлтийг удирдлагад танилцуулсан.</p>		
		<p>1.3. Шинэчлэн батлагдсан “Цагдаагийн алба хаагчийн ёс зүйн дүрэм”-ийг алба хаагчдаар судлуулж мөрдүүлэх ажлыг зохион</p>	<p>Цагдаагийн ерөнхий газрын Цагдаа, дотоодын цэргийн сургалтын нэгдсэн төвд зохион байгуулсан “Алба хаагчдыг ёс зүйн төлбөртэй сургалт”-д тус газрын харьяа газар, хэлтэс, дүүрэг дэх цагдаагийн хэлтсийн 107 алба хаагчийг хамруулав. Шинэчлэн батлагдсан “Цагдаагийн алба хаагчийн ёс зүйн дүрэм”-ийг алба хаагчдаар бие</p>	<p>100</p>	<p>5</p>

		байгуулах.	даан судлуулж, үйл ажиллагаанд нь мөрдлөг болгох ажлыг зохион байгуулж байна.		
2	Иргэдийн өргөдөл /санал, мэдэгдэл/, гомдол, хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх шат дамжлагыг цөөрүүлэх, зөрчлийн талаарх мэдээллийг хүлээн авч шалгах. /цагдаагийн алба хаагчтай холбоотой/	2.1. Иргэний гаргасан өргөдөл, гомдлыг хүлээн авах албан тушаалтны нэр, ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарийг цахим хуудас, мэдээллийн самбарт байршуулах	Тус цагдаагийн газрын цахим хуудасны “Холбоо барих” хэсэгт 35 алба хаагчийн харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарийг байршуулсан. Мөн төв байрны угтах үйлчилгээний иргэдэд зориулсан мэдээллийн самбарт дээрх алба хаагчдын мэдээллийг байршуулсан. Мөн тус цагдаагийн газрын Хяналт шалгалт ёс журмын хэлтэст 2018 оны эхний 10 сарын байдлаар иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа болон алба хаагчийн ёс зүйтэй холбоотой нийт 52 гомдол гаргасныг хүлээн авч, шалгаж, шийдвэрлэсэн байна. Одоо 2 гомдол мэдээлэл шалгаж, шийдвэрлэгдээгүй байна.	100	5
		2.2. Иргэн гаргасан өргөдөл, гомдлоо цахим хэлбэрээр хянах, ямар шатанд байгааг мэдээлэх нээлттэй суваг ажиллуулах.	Тус цагдаагийн газар нь “Smart.City” программаар 2018 оны 10 дугаар сарын байдлаар иргэд аж ахуйн нэгж байгууллагаас Засгийн газрын 11-11 төвөөс 49, 1200-1800 тусгай дугаараас 6, Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвөөс 6, “UB-1200.m.n” цахим сайтаар 9, гар утсны апплекшнээр 4 буюу нийт 74 гомдол, мэдээлэл, хүсэлт, санал, талархал /гомдол-25, санал-4, хүсэлт-16, талархал-29/ хүлээн авч, шалгаж шийдвэрлэн, 73 иргэн, аж ахуйн нэгж байгууллагад хариуг өгч, одоо 1 гомдол, мэдээлэл шийдвэрлэгдээгүй, хуулийн хугацаандаа байна. Тус цагдаагийн газар нь цагдаагийн байгууллага болон алба хаагчтай холбоотой иргэд аж ахуй нэгжээс гаргасан санал, хүсэлт, өргөдөл, гомдол, мэдээллийг хүлээн авах 70191212, 70191515, 102 дугаарын утас, <a href="http://www.smartcity.mn">www.smartcity.mn</a> цахим хуудсанд суурилсан онлайн аппликейшн ашиглан бүртгэж хүлээн авч Хяналт шалгалт хариуцсан ахлах байцаагч нар шалгалтын ажиллагааг явуулан, шалгаж шийдвэрлэн, албан бичгээр хариуг өгч ажиллаж байна. Иргэн гаргасан өргөдөл, гомдлоо цахим хэлбэрээр хянах, ямар шатанд байгааг мэдээлэх нээлттэй суваг ажилладаггүй ч тус газрын цахим хуудас, фейсбүүк хуудсаар иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдлын шалгалтын явц байдлын талаар тухайн иргэнд мэдээлж ажиллаж байна. Тус байрны нэг давхарт иргэд, аж ахуйн нэгжээс цагдаагийн алба хаагчидтай холбоотой бичгээр гаргасан санал хүсэлтийг хүлээн авах хайрцгийг ажиллуулж байна.	100	5
3	Авлигын шинжтэй буюу сонирхлын зөрчилтэй холбоотой асуудлаар Авлигатай тэмцэх газарт	3.1. Алба хаагчдын хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг нэгтгэн, хуулийн хугацаанд нь	Авилгын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу алба хаагчдын 2017 оны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн	100	5

	мэдээлэх.	Авлигатай тэмцэх газарт хүргүүлэх.	бүрдүүлэлтийн үйл ажиллагааг байгууллагынхаа хэмжээнд 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 02 дугаар сарын 15-ны өдрүүдэд зохион байгуулж, хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргаж өгөх нийт 1447 алба хаагчдаас 1441 алба хаагчид мэдүүлгээ цахимаар өгснийг баталгаажуулж, ажлаа хаяж явсан шалтгаанаар мэдүүлгээ гаргаж өгөөгүй 6 алба хаагчдын мэдээлэл, тайлбарыг Цагдаагийн ерөнхий газрын Аюулгүй байдлыг хэлтсийн эрх бүхий албан тушаалтанд хүргүүлсэн.		
		3.2. Шинээр томилогдсон, их хэмжээний өөрчлөлт орсон алба хаагчдаас тухай бүр мэдүүлгийг гаргуулан авч цахим санд оруулах, түүнд хяналт тавих.	Энэ оны 10 сарын байдлаар тус газарт болон харьяа газар, хэлтэст шинээр томилогдсон 88, ажлын байр өөрчлөгдсөн шилжин томилогдсон 200, эд хөрөнгийн их хэмжээний өөрчлөлт орсон 4 алба хаагчдаас тус тус мэдүүлгийг гаргуулан авч, цахим санд оруулж, Цагдаагийн ерөнхий газрын Аюулгүй байдлын хэлтсийн эрх бүхий албан тушаалтанд мэдэгдсэн байна.	100	5
		3.3. Ашиг сонирхлын зөрчлийн мэдэгдэл, тайлбарыг гаргаж хэвших. Цахим санд оруулах, түүнд хяналт тавих.	Тус цагдаагийн газрын даргын 2018 оны зөвлөлийн ээлжит хурлаар хүний нөөцийн шилжилт хөдөлгөөн, томилолтын асуудал нь дэмжигдсэн нэр бүхий 167 алба хаагчдын хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг шалгуулахаар холбогдох материалын хамт Цагдаагийн ерөнхий газрын Хүний нөөц, сургалтын хэлтэст хүргүүлсэн.	100	5
4	Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах.	4.1. Авлигын сэжигтэй тохиолдол болон авлига өгөхөөр оролдсон, санал болгосон, зуучилсан талаарх мэдээллийг шалгах, харьяаллын дагуу шилжүүлэн шийдвэрлүүлэх, хяналт тавих.	Тус цагдаагийн газрын Хяналт шалгалт, үнэлгээ ёс журмын хэлтэст иргэн Ө.Энхзаяагаас “Чингэлтэй дүүрэг дэх цагдаагийн хоёрдугаар хэлтсийн Мөрдөн байцаах тасгийн мөрдөгч, цагдаагийн ахлах дэслэгч О.Серик нь иргэн хүнтэй харилцахад харилцааны соёлгүй, үл ойшоосон зан гаргадаг, иргэн хүнийг залилж 500.000 төгрөгийн хахууль авсан” гэх гомдол гаргасныг хүлээн авч, албаны шалгалт явуулахад Эрүүгийн хуулийн тусгай ангийн 22.4 дүгээр зүйл “Хахууль авах”-д заасан гэмт хэргийн шинжтэй байсан тул албаны шалгалтын материалыг 2018 оны 05 дугаар сарын 10-ны өдөр 30е/3082 тоот албан бичгээр Авлигатай тэмцэх газарт шилжүүлсэн байна. Тус газрын Хяналт шалгалт, үнэлгээ, ёс журмын хэлтсийн жижүүрийн цагдаа, цагдаагийн дэд ахлагч С.Баясгаланбаяр нь амарч байх үедээ бусдын биед гэмтэл учруулсан гэх үндэслэлээр Авлигатай тэмцэх газарт шалгагдан, одоогийн байдлаар эцэслэн шийдвэрлэгдээгүй байна. Харьяа Баянгол дүүрэг дэх цагдаагийн хоёрдугаар хэлтсийн Нийтийн хэв журам хамгаалах тасгийн цагдаа-жолооч, цагдаагийн дэд ахлагч М.Пүрэвцэрэн, Эрүүгийн цагдаагийн тасгийн эрүүгийн мөрдөгч, цагдаагийн ахмад Ч.Очирбат нар нь бусдаас шан,	100	5

			<p>харамж авсан, цагдаа-жолооч, цагдаагийн ахлах ахлагч Д.Батдэлгэр нь албан үүргээ гүйцэтгэж байгаа бусдын биед гэмтэл учруулсан гэх үндэслэлээр Авлигатай тэмцэх газарт шалгагдан, Нийтийн хэв журам хамгаалах тасгийн цагдаа-жолооч, цагдаагийн дэд ахлагч М.Пүрэвцэрэн нь иргэнээс авлига авсан болох нь тогтоогдож, Баянгол дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн №308 дугаартай шийтгэх тогтоолоор Эрүүгийн хуулийн 24.4 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт зааснаар Нийтийн албанд томилогдох эрхийг 3 жилийн хугацаагаар хасаж, 10.000.000 төгрөгийн торгууль ногдуулсан тул тус цагдаагийн газрын даргын 2018 оны 06 дугаар сарын 14-ны өдрийн № 472 дугаартай тушаалаар албанаас халах сахилгын шийтгэл ногдуулсан.</p> <p>Мөн эрүүгийн цагдаагийн тасгийн эрүүгийн мөрдөгч, цагдаагийн ахмад Ч.Очирбат нь бусдаас шан харамж авсан болох нь тогтоогдож Эрүүгийн хуулийн 24.4 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт зааснаар Нийтийн албанд томилогдох эрхийг 3 жилийн хугацаагаар хасаж, 10.000.000 төгрөгийн торгууль ногдуулсан тул Цагдаагийн ерөнхий газрын даргын 2018 оны 07 дугаар сарын 17-ны өдрийн № Б/507 дугаартай тушаалаар албанаас халах сахилгын шийтгэл ногдуулсан.</p> <p>Цагдаа-жолооч, цагдаагийн ахлах ахлагч Д.Батдэлгэрийн хэрэг одоогийн байдлаар эцэслэн шийдвэрлэгдээгүй байна.</p> <p>Энэ оны 10 дугаар сарын байдлаар Сонгинохайрхан дүүрэг дэх цагдаагийн нэгдүгээр хэлтсийн Эрүүгийн цагдаагийн тасгийн эрүүгийн мөрдөгч, цагдаагийн ахлах дэслэгч С.Төгөлдөр, Нийтийн хэв журам хамгаалах тасгийн эргүүлийн офицер, цагдаагийн ахмад Б.Батдорж, цагдаа-жолооч, цагдаагийн ахлах ахлагч Ө.Энхбаатар нар нь бусдаас шан харамж авсан, эргүүлийн офицер, цагдаагийн дэслэгч Ч.Энхболд, эргүүлийн цагдаа-жолооч, цагдаагийн ахлах ахлагч Б.Нямдулам нар нь бусдыг залилсан, эргүүлийн офицер, цагдаагийн дэд ахлагч Э.Билэгүтэй нь бусдыг хүчиндсэн гэх үндэслэлээр Авлигатай тэмцэх газарт шалгагдан, цагдаагийн дэд ахлагч Э.Билэгүтэй нь Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн №792 дугаартай шийтгэх тогтоолоор Эрүүгийн хуулийн 12.1 дүгээр зүйлийн 2.3 дэх хэсэгт зааснаар 1 жилийн хорих ногдуулсан байна.</p> <p>Эрүүгийн цагдаагийн тасгийн эрүүгийн мөрдөгч, цагдаагийн ахлах дэслэгч С.Төгөлдөр , эргүүлийн офицер, цагдаагийн ахмад Б.Батдорж, цагдаагийн дэслэгч Ч.Энхболд, цагдаа-жолооч,</p>		
--	--	--	---	--	--

			цагдаагийн ахлах ахлагч Ө.Энхбаатар, Б.Нямдулам нарын хэрэг одоогийн байдлаар эцэслэн шийдвэрлэгдээгүй байна.		
5	Авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг хариуцан зохион байгуулах, уг асуудлаар Авлигатай тэмцэх газартай харилцах эрх бүхий албан тушаалтан-тай байх.	5.1. Цагдаагийн байгууллагын салбарын эрх бүхий албан тушаалтан /ЭБАТ/-ууд солигдсон тохиолдолд тухай бүр шинэчлэн томилуулж, ажлын байр /албан тушаал/-ны тодорхойлолтыг боловсруулж батлуулах. ЭБАТ-ын нэмэгдлийг шийдвэрлүүлэх.	Тус газрын эрх бүхий 2 албан тушаалтны ажлын байр /албан тушаал/ өөрчлөгдсөн тул шинээр томилогдсон 2 алба хаагчид ажлын байрны тодорхойлолт, ажил үүргийн хуваарийг нь танилцуулж, нэмэгдлийг олгон ажиллуулж байна.	100	5
6	Нийтийн албан тушаалтанд холбогдох авлига, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой гомдол, мэдээллийг хүлээн авах, хянан шалгах, хариуцлага хүлээлгэх арга хэлбэрийг тодорхой болгож, дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх.	6.1. Алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн газар, хэлтсүүдийн мэдээллийн самбарт тусгайлан мэдээлэл хүлээн авах утасны дугаарыг байрлуулж, мэдээллийн дагуу шалгах үйл ажиллагааг тогтмолжуулах.	Авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр бэлтгэсэн “Авлига үгүй” нэртэй сурталчилгааны 20х30 хэмжээтэй зурагт хуудсыг Нийслэлийн цагдаагийн газрын нэг, хоёрдугаар байрны Мэдээллийн самбар, алба хаагчдын 22 ажлын өрөөний хаалга, тус газрын угтах үйлчилгээний танхимд тус тус байршуулсан. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг сурталчлах, иргэд, олон нийтэд мэдээллийг ил тод шуурхай хүргэх зорилгоор байгууллагын цахим хуудасны “Ил тод байдал” цэсэд Авлигын эсрэг үйл ажиллагаа дэд цэсийг шинээр үүсгэж, Авлигын үйл ажиллагааны төлөвлөгөө, мэдүүлгийн бүрдүүлэлтийн талаар хийсэн үйл ажиллагааны танилцуулга, цахим хуудасны Видео мэдээлэл хэсэгт “Авлигын эсрэг хамтдаа” 30 секундын бичлэгийг 2 удаа байршуулж, 120 удаа бусадтай хуваалцан, давхардсан тоогоор 488 хэрэглэгч хандалт хийсэн байна. Мөн байгууллагын олон нийтийн сүлжээ хуудас /facebook, twitter/-нд байршуулж иргэд, олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулсан.	100	5
<b>ХОЁР: АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР</b>					
7	Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд	7.1. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний нэг дэх үе шатны төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллах, хяналт тавих.	Цагдаагийн ерөнхий газрын “Авлигаас урьдчилан сэргийлэх”, “Авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх” үйл ажиллагааны 2018 оны төлөвлөгөөний дагуу тус цагдаагийн газраас 2018 оны 02 дугаар сарын 22-ны өдөр 22 заалт 42, 9 заалт 19 ажил зохион байгуулах салбар төлөвлөгөө тус гарган, батлуулж, харьяа дүүрэг дэх цагдаагийн хэлтсүүдэд энэ оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 14е/1393 дугаартай албан бичгээр хүргүүлж, биелэлтийг тооцохоор хяналт тавин, “Авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх” үйл ажиллагааны төлөвлөгөөний хагас жилийн биелэлтийг харьяа дүүрэг дэх цагдаагийн хэлтсүүдээс авч нэгтгэн, Цагдаагийн ерөнхий газрын Аюулгүй байдлын хэлтэст 2018 оны 06 дугаар сарын 15-ны өдөр 30е/3961 дугаартай албан бичгээр	100	5

			<p>хүргүүлсэн байна.</p> <p>Авлигатай тэмцэх газрын даргын 2018 оны 03 дугаар сарын 01-ний өдөр баталсан удирдамжийн дагуу тус цагдаагийн газрын Хүний нөөц, сургалт, Урьдчилан сэргийлэх, Санхүү аж ахуйн хэлтсүүдэд 2018 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн 14е/1540 дугаартай албан бичиг хүргүүлж, 2017, 2018 онуудад хийж гүйцэтгэсэн ажлын биелэлт, явц үр дүнгийн талаар танилцуулгыг 2018 оны 03 дугаар сарын 15-ны өдөр авч, нэгтгэн ажилласан.</p>		
		<p>7.2. Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг хэрэгжүүлэх, анхаарах асуудлаар нийт алба хаагчдын дунд сургалт зохион байгуулах.</p>	<p>Авлигатай тэмцэх газрын Олон нийтийн төвд зохион байгуулагдсан “Мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах эрх бүхий албан тушаалтнуудын сургалт”-д тус газраас 12 алба хаагчийг, Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 114 дүгээр тогтоолоор баталсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд Авлигатай тэмцэх газрын Олон нийтийн төвд зохион байгуулагдсан “Авлигын эсрэг” сэдэвт 10 удаагийн сургалтад тус цагдаагийн газар, хэлтэс, дүүрэг дэх цагдаагийн хэлтсийн 123 алба хаагчийг тус тус хамруулж, байгууллагын хэмжээнд авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр 2 удаа сургалт зохион байгуулж, нийт 95 алба хаагчийг хамруулж, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон холбогдох эрх зүйн актуудыг нийт бие бүрэлдэхүүнд бие даан судлуулж, Авлигын эсрэг болон бусад холбогдох хууль, тогтоомжийн мэдлэгийг сорих 20 асуулт бүхий тестээр 183 алба хаагчдаас 2 удаа шалгалт авч, дүнг нэгтгэн Дэд бөгөөд захиргааны удирдлагын газрын даргад танилцуулсан.</p>	100	5
<b>ГУРАВ: МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫГ ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР</b>					
8	<p>Хүний нөөцийн ил тод байдлыг хангах, олон нийтийг түүнтэй танилцах боломжоор хангах.</p>	<p>8.1. Албан тушаалтанд тавигдах ёс зүй, мэдлэг, боловсрол, туршлага, ур чадварын ерөнхий болон тусгай шалгуурыг үндэслэн төрийн албанд томилох, дэвшүүлэх тогтолцоог бүрдүүлэх.</p>	<p>Нийслэлийн цагдаагийн газрын даргын зөвлөлийн ээлжит болон ээлжит бус 12 удаагийн хуралд албан тушаал /ажлын байр/ дэвшүүлэх 126 /тасаг, хэсгийн дарга 6, ахлах албан тушаалд 49, офицерын бүрэлдэхүүнд оруулах 71/, ажлын байр /албан тушаал/ өөрчлөн томилуулах 10, сул ажлын байр /албан тушаал/-нд томилуулах 5, шилжүүлэх 14, оршин суугаа хаягийн дагуу шилжүүлэн томилуулах 18 алба хаагчийн асуудлыг хэлэлцүүлж, холбогдох материалыг Цагдаагийн ерөнхий газрын холбогдох газар, хэлтэст хүргүүлэн шийдвэрлүүлэв.</p> <p>Харьяа газар, хэлтсийн ахлагч бүрэлдэхүүнээс офицер бүрэлдэхүүнд оруулж дэвшүүлэн томилох асуудлыг ил тод нээлттэй болгох зорилгоор цагдаагийн байгууллагын ажилтан бэлтгэх үндсэн чиг үүрэг бүхий Хууль сахиулахын их сургуулийг</p>	100	5

			<p>төгссөн болон бусад их дээд сургуулийг төгссөн 61 ахлагчийг дэвшүүлэн томилуулах судалгааг гаргаж, болзол шаардлага хангасан алба хаагчдын хуулиар нууцалбал зохих мэдээллээс бусад мэдээллийг байгууллагын цахим хаягт ил тод байршуулан 48 ахлагчийн томилгооны асуудлыг тус газрын даргын зөвлөлийн 15 удаагийн хурлаар хэлэлцүүлж, Цагдаагийн ерөнхий газрын Хүний нөөц, сургалтын хэлтэст материалыг саналын хамт хүргүүлснээр 45 ахлагчийг офицерын албан тушаалд томилуулсан шинэлэг ажлыг зохион байгуулав.</p> <p>Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/248 дугаар тушаалаар баталсан “Албан тушаал дэвшүүлэх” журам /код 909/-ын 909.7-д заасны дагуу тус газрын харьяа газар, хэлтсүүдээс нийт 449 алба хаагчийн албан тушаал дэвшүүлэх нөөцөд бүртгүүлэх санал, материалыг хүлээн авч, журам /код 909/-ын 909.5-д заасан болзол, шаардлагыг хангаагүй 55 алба хаагчийг хасаж, бичгээр хариу мэдэгдэв. Шаардлага хангасан 394 алба хаагчийн албан тушаал дэвшүүлэх нөөцөд авах асуудлыг тус газрын даргын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэн Цагдаагийн ерөнхий газарт хүргүүлснээр нөөцөд авахуулж, Төрийн албаны салбар зөвлөлийн 2018 оны 02 дугаар тогтоолоор баталгаажуулав. Нөөцийн жагсаалтаас хэлтсийн даргаар 1, дэд даргаар 2, тасаг, хэсгийн даргаар 2, ахлах албан тушаалд 9, ахлагчаас офицерын албан тушаалд 52 нийт 66 алба хаагчийг тус тус албан тушаал дэвшүүлэн томилуулсан.</p> <p>Цагдаагийн ерөнхий газрын дэргэдэх Төрийн албаны салбар зөвлөлөөс 2018 оны 01, 09 дүгээр сард цагдаагийн байгууллагын төрийн тусгай албан тушаалын сул орон тооны ажлын байрыг зарласантай холбогдуулан мэргэшлийн шалгалтын зар, холбогдох мэдээллийг иргэдэд байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбарт байршуулан зарлан мэдээлж, төрийн үйлчилгээг иргэдэд цахим хэлбэрээр хүргэх тогтолцоог бүрдүүлэх зорилгоор Цагдаагийн ерөнхий газрын Хүний нөөцийн хэлтэстэй хамтран сонгон шалгаруулалтад оролцох хүсэлт гаргасан 293 иргэний хүсэлт, холбогдох мэдээллийг цахим хэлбэрээр бүртгэн авч, нийт 528 иргэнийг судлав. Болзол, шаардлага хангасан 251 иргэнийг мэргэшлийн шалгалтад хамруулж, тэнцсэн 196 иргэнийг Төрийн албаны салбар зөвлөлийн 2018 оны 01, 07 дугаар тогтоолоор цагдаагийн байгууллагын төрийн тусгай албан тушаалд анх орох иргэний нөөцөд бүртгүүлэв. Нөөцийн жагсаалтаас онооны дарааллаар 83 иргэнийг ахлагчийн сул орон тоонд, 4 иргэнийг офицерын албан тушаалд тус тус томилуулсан байна.</p>	
--	--	--	---	--



**ДӨРӨВ: ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР**

9	<p>Төсвийн орлого, түүний зарцуулалт, гадаадын зээл, тусламж, түүний хуваарилалтыг олон нийтэд тухай бүр мэдээлэх.</p>	<p>9.1. Өмнөх оны болон сар, улирал, хагас, бүтэн жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг цахим хуудсанд байршуулах.</p>	<p>Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 17 дугаар тогтоолоор баталсан “Төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангахад дагаж мөрдөх журам”-ын 4.3.2, 4.5 дах заалт, Монгол улсын Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоол, Цагдаагийн байгууллын үйл ажиллагааны журам /код135/-д заасны дагуу тус газрын 2018 оны 01-10 дугаар сарын төсвийн гүйцэтгэлийн санхүүгийн нэгдсэн мэдээ, төсвийн орлого, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого зарлагын мөнгөн гүйлгээ, худалдан авалтыг <a href="http://www.shilendans.gov.mn">www.shilendans.gov.mn</a>, <a href="http://www.ub.police.gov.mn">www.ub.police.gov.mn</a> цахим сайтад болон тус газрын мэдээллийн самбарт тавин, олон нийтэд мэдээлснийг 12.000 гаруй хэрэглэгч хандалт хийсэн байна. Мөн төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангах чиглэлээр Шилэн данс цэсний 9 дэд хэсэгт 2017 оны аудитын дүгнэлт, тендерийн урилга зэрэг 11 мэдээллийг тухай бүр, аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 06 дугаар сарын 30-ны өдөр, 2018 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланг 2018 оны 07 дугаар сарын 23-ны өдөр тус тус байршуулсан.</p> <p>Харъяа дүүрэг дэх цагдаагийн газар, хэлтсүүдийн шилэн дансны нэгдсэн сайтад байршуулсан мэдээллийг улирал бүрийн 30-ны өдөр шалгаж, дутуу байршуулсан мэдээллийг тухай бүрт нь залруулан, 2 удаа үүрэг, ажлын чиглэл хүргүүлэн биелэлт үр дүнг тооцон, тайлан мэдээг Цагдаагийн ерөнхий Хяналт шалгалт, дотоод аудитын хэлтэст улирал бүрийн 05-ны дотор цахимаар хүргүүлэн ажиллаж байна.</p>	100	5
	<p>9.2. Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь цахим хуудсанд байршуулах, аудитын байгууллагын акт, албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээг авч ажиллах, нэгжүүдэд бүрэн мэдээлсэн байх.</p>	<p>Аудитын шалгалтыг төрийн аудитын тухай хуулийн 15.1 Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу 2017 оны 12 сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийлгэхээр Нийслэлийн төрийн аудитын газарт хүргүүлж зөрчилгүй санал дүгнэлт авч ажиллаж аудитын тайланг <a href="http://www.shilendans.gov.mn">www.shilendans.gov.mn</a>, <a href="http://www.ub.police.gov.mn">www.ub.police.gov.mn</a> сайтад байршуулан олон нийтийг мэдээллээр ханган ажиллаж байна. Сайтад байршуулсан мэдээллийг 12.000 гаруй хэрэглэгч хандалт хийсэн байна.</p> <p>Мөн харъяа дүүрэг дэх цагдаагийн хэлтсүүдийн аудитын тайланг байгууллагын сайт болон шилэн дансны нэгдсэн сайтад байршуулсан эсэхийг энэ оны 10 дугаар сарын байдлаар шалгаж, байршуулаагүй байсан 2 дүүрэг дэх цагдаагийн хэлтсийн тайланг нөхөн байршуулсан.</p>	100	5	

	9.3. Төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбарыг цахим хуудсанд байршуулах	Монгол улсын шилэн дансны тухай хууль, Засгийн газрын 29 дугаар тогтоолын хэрэгжилтийг ханган тус газрын төсвийн хэмнэлт, хэтрэлт түүний шалтгааныг тогтоож, дараа сарын 08-ны дотор шилэн дансны нэгдсэн систем болон байгууллагын сайтад 10 удаа байршуулан ажилласан байна.	100	5
	9.4. Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт өөрчлөлт, гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр, түүний хэрэгжилтийн талаарх мэдээллийг цахим хуудсанд байршуулах.	2018 оны эхний 10 сарын байдлаар Сангийн сайдын 73 тогтоолын хүрээнд төсвийн хөдөлгөөнөөр өөрчлөлт оруулах саналыг 2018 оны 03, 05, 09 дүгээр саруудад тус тус гурав удаа төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлсэн. Уг саналын дагуу төсвийн хөдөлгөөн нэг удаа хийгдсэнийг өөрчлөлт орсон тухай бүрт нь 11 удаа шилэн дансны нэгдсэн сайт болон байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбарт байршуулан олон нийтэд хүртээмжтэй байдлаар харагдуулан ажилласан байна.	100	5
<b>Нийт 18 арга хэмжээ 100 % буюу 5 үнэлгээтэй байна.</b>				

ХЯНАСАН:

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ҮНЭЛГЭЭ, ЁС ЖУРМЫН ХЭЛТСИЙН

ДАРГА, ЦАГДААГИЙН ХУРАНДАА

Г.ТӨГӨЛДӨР

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:

ЁС ЖУРМЫН ЖИЖҮҮРИЙН АХЛАХ БАЙЦААГЧ,

ЦАГДААГИЙН ХОШУУЧ

Л.МӨНХБОЛД